

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ  
ХҮҮХДИЙГ ХУДАЛДАХ, ХҮҮХДИЙН БИЕИЙГ ҮНЭЛЭХ, ХҮҮХДИЙГ САДАР САМУУНД  
СУРТАЛЧЛАХЫН ЭСРЭГ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦИД ОРУУЛАХ НЭМЭЛТ  
ПРОТОКОЛ

2000 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Ерөнхий Ассамблейн 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн A/RES/54/263 тогтоолоор баталж, 2002 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон\*

Энэхүү Протоколын оролцогч улсууд,  
Хүүхдийн эрхийн тухай конвенцийн зорилтыг цаашид хангах болон түүний заалтуудыг хэрэгжүүлэх үүднээс, ялангуяа 1, 11, 21, 32, 33, 34, 35 болон 36 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэхийн тулд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах явдлаас хүүхдийг хамгаалах зорилгоор оролцогч улсуудын зүгээс илүү өргөн хүрээний арга хэмжээ авбал зохино хэмээн үзэж,  
эдийн засгийн дарангуйлал болон эрүүл мэндэд нь аюул учруулах буюу сурч боловсроход нь саад хийх мөн хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл санаа, оюун санаа болон сэтгэл зүй, ёс суртахуун болон нийгмийн хөгжилд хохирол учруулах аливаа хөдөлмөр эрхлүүлэхээс хүүхдийн эрхийг хамгаалах талаар Хүүхдийн эрхийн тухай конвенцид хүлээн зөвшөөрснийг мөн харгалзан үзэж,  
хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах зорилгоор олон улсын хэмжээнд хууль бусаар хил зувчуулан тээвэрлэх явдал мэдэгдэхүйц нэмэгдэж байгаад гүнээ харамсаж,  
хүүхдэд аюултай секс аялал өргөжин үргэлжилж, ялангуяа энэ нь хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлахад шууд дөхөм үзүүлж байгаад сэтгэл гүнээ зовниж,  
бага насны охидыг оролцуулан эмзэг бүлгийн хүүхдүүд бэлгийн хүчирхийлэлд илүү өртөж байгаа бөгөөд бэлгийн



хүчирхийлэлд өртөгсдийн харьцангуй дийлэнх хувийг бага насны охид эзэлж байгааг хүлээн зөвшөөрч, Интернэт болон бусад дэвшилт технологийн хүчээр хүүхдийг садар самуунд сурталчлах явдал нэмэгдэж байгаад сэтгэл зовнин, мөн интернэтээр хүүхдийг садар самуунд сурталчлахтай тэмцэх асуудлаарх бага хурал /Вена, 1999/, ялангуяа түүний хүүхдийг садар самуунд сурталчилсан дүрс бичлэг, зар сурталчилгааг дэлхий нийтээр үйлдэх, тараах, экспортлох, дамжуулах, импортлох, санаатайгаар хадгалах нь гэмт хэрэг гэж үзсэн болон засгийн газрууд, интернэтээр мэдээлэл түгээгчдийн хооронд илүү хамтын ажиллагаа, түншлэл тогтоох нь чухал ач холбогдолтой гэж үзсэн шийдвэрийг иш үндэс болгон, хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах явдлыг арилгахын тулд ийм байдал уруу түлхэж байгаа хүчин зүйлс, тухайлбал буурай хөгжил, ядуурал, эдийн засгийн тэнцвэргүй байдал, нийгэм эдийн засгийн тэгш бус байдал, гэр бүлийн гишүүдийн хоорондын таарамжгүй байдал, боловсролын дутагдал, хот хөдөөгийнхний шилжилт хөдөлгөөн, хүйсээр ялгаварлах байдал, бэлгийн харилцаанд насанд хүрэгчдийн хариуцлагагүй үйлдэл, уламжлалт зан заншлын хортой хэлбэр, зэвсэгт мөргөлдөөн болон хүүхдийг хууль бусаар хил зувчуулан тээвэрлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх нь дээрх байдлыг арилгахад тус дөхөм үзүүлнэ гэж үзэж, хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах эрэлт хэрэгцээг багасгахын тулд олон нийтийн дунд мэдээллийг сайжруулах чиглэлээр хүчин чармайлт тавих хэрэгтэй бөгөөд оролцогч бүх талын хооронд даяаршлын түншлэлийг бэхжүүлэх талаар онцгой анхаарч, үндэсний хэмжээнд хуулийн хэрэгжилтийг сайжруулах нь чухал гэж үзэж, хүүхдийг хамгаалахтай холбогдсон олон улсын эрх зүйн баримт бичиг, тухайлбал,



Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн конвенц, Олон улсын хэмжээнд хүүхдийг хууль бусаар зөөхтэй холбогдон үүсэх иргэний асуудлын тухай Гаагийн конвенц, Эцэг эхийн зүгээс хүлээх хариуцлага болон хүүхдийн эрхийг хамгаалах хууль, тэдгээрийг хүлээн зөвшөөрөх, мөрдүүлэх болон хамтран ажиллах тухай Гаагийн конвенц болон Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглож устгах тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар конвенцийн заалтыг анхааралдаа авч, хүүхдийн эрхийг хамгаалах болон дэмжлэг үзүүлэх үйл хэрэгт бүх талаар үйлчилж буй Хүүхдийн эрхийн тухай конвенцийг бүх нийтээрээ дэмжиж байгаад урамшин, Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлахыг таслан зогсоох үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт болон Арилжааны зорилгоор хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд ашиглахын эсрэг 1996 оны наймдугаар сарын 27-оос 31-ний өдрүүдэд болсон Дэлхий дахины их хурлын тунхаглал болон үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох бусад олон улсын байгууллагаас энэ асуудлаар гаргасан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх нь чухал болохыг хүлээн зөвшөөрч, хүүхдийг хамгаалах, өв тэгш хөгжүүлэх талаар ард түмнүүдийн зан заншил, соёлын үнэт зүйлсийг чухалчлан, зохих ёсоор харгалзан үзэж, дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл  
Энэхүү Протоколд зааснаар оролцогч улсууд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлахыг хориглоно.

2 дугаар зүйл  
Энэхүү Протоколын зорилгод:  
(а) хүүхдийг худалдах гэж аливаа этгээд буюу бүлэг этгээд шан харамж буюу бусад аливаа төлбөр авч хүүхдийг бусад этгээд



буюу бүлэг этгээдэд шилжүүлэн өгөх аливаа үйлдэл буюу хэлцлийг хэлнэ;

(b) хүүхдийн биеийг үнэлэх гэж шан харамж буюу бусад аливаа төлбөрийн хэлбэрээр хүүхдийг бэлгийн харилцаанд ашиглахыг хэлнэ;

(c) хүүхдийг садар самуунд сурталчлах гэж хүүхдийг ил тод бэлгийн харилцаанд бодитоор буюу хиймлээр оруулж байгааг аливаа арга хэрэгслээр илэрхийлэх буюу гол нь бэлгийн харилцааны зорилгоор хүүхдийн бэлэг эрхтнийг аливаа байдлаар харуулахыг хэлнэ.

3 дугаар зүйл

1. Оролцогч улс бүр эрүүгийн болон гэмт хэргийн талаархи хуулиндаа дор хаяж дараахь үйлдэл болон үйл ажиллагааг бүрэн хамааруулж, эдгээр гэмт хэрэг улсын дотоодод буюу үндэстэн дамнасан болон ганцаарчилсан буюу зохион байгуулалттай хэлбэрээр үйлдэгдсэнийг харгалзахгүйгээр хариуцлага хүлээлгэх талаар:

(a) 2 дугаар зүйлд тодорхойлсон хүүхдийг худалдахтай холбогдуулан:

(i) хүүхдийг аливаа арга хэрэгслээр дараахь зорилгоор санал болгох, шилжүүлэх буюу авах:

a. бэлгийн хүчирхийлэлд ашиглах;

b. шан харамж авч хүүхдийн эрхтэнг шилжүүлэх;

c. хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхэхэд ашиглах;

(ii) хүүхэд үрчлэх үйл ажиллагаанд зуучлахдаа хүүхэд үрчлэх тухай олон улсын эрх зүйн баримт бичгийн заалтыг зөрчиж хууль бус арга хэрэглэн зөвшөөрүүлэх,

(b) 2 дугаар зүйлд тодорхойлсны дагуу хүүхдийн биеийг үнэлэх зорилгоор хүүхдийг санал болгох, авах, шилжүүлэх болон өгөх;

(c) 2 дугаар зүйлд тодорхойлсны дагуу дээрх зорилгод ашиглахаар хүүхэд оролцсон садар самуун сурталчилгааг үйлдэх, түгээх, тараах, импортлох, санал болгох, худалдах буюу хадгалах.

2. Оролцогч улсын үндэсний хууль тогтоомжийн заалтаас хамааран эдгээр



үйлдлийн аль нэгийг хийхээр оролдсон, хамтран оролцсон буюу оролцсон тохиолдолд дээрх заалт мөн адил үйлчилнэ.

3. Эдгээр гэмт хэргийн гэм хор үзүүлсэн зэрэглэлийг харгалзан оролцогч улс бүр зохих шийтгэл ногдуулна.

4. Оролцогч улс бүр үндэсний хууль тогтоомжийн заалтаас хамааран энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол түүний хүлээх хариуцлагыг тогтоох талаархи арга хэмжээг зохих үед авна. Оролцогч улсын эрх зүйн зарчмаас хамааран хуулийн этгээдийн хариуцлага нь эрүүгийн, иргэний болон захиргааных байж болно.

5. Оролцогч улсууд хүүхэд үрчлэх асуудалтай холбогдсон бүх этгээд олон улсын эрх зүйн баримт бичигт тусгасан хэм хэмжээний дагуу үйл ажиллагаа явуулахад зориулж эрх зүйн болон захиргааны холбогдох арга хэмжээ авна.

4 дүгээр зүйл

1. Оролцогч улс бүр 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэргийн хувьд тухайн гэмт хэрэг түүний нутаг дэвсгэрт буюу далайн боомтод, эсхүл уг улсад бүртгэлтэй агаарын хөлөгт үйлдэгдсэн тохиолдолд өөрийн шүүх эрх мэдлийг тогтоохоор зайлшгүй гэж үзсэн арга хэмжээ авч болно.

2. Оролцогч улс бүр 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэргийн хувьд өөрийн шүүх эрх мэдлийг тогтоохоор зайлшгүй гэж үзсэн арга хэмжээ дараахь тохиолдолд авч болно:

(а) хэрэгтэн тухайн улсын иргэн буюу уг этгээдийн оршин суугаа газар тухайн улсын нутагт дэвсгэрт байрладаг бол;

(b) хохирогч тухайн улсын иргэн бол.

3. Оролцогч улс бүр дээр дурдсан гэмт хэргийн хувьд өөрийн шүүх эрх мэдлийг тогтоохоор зайлшгүй гэж үзсэн арга хэмжээг тухайн хэрэгтэн түүний нутаг дэвсгэрт байгаа болон гэмт хэргийг түүний иргэн үйлдсэн гэсэн үндэслэлээр уг улс хэрэгтэнг оролцогч өөр улсад шилжүүлэхгүй байх арга хэмжээ авч болно.



4. Энэхүү Протокол нь дотоодын хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж буй эрүүгийн аливаа хуулийн эрх мэдлийг хязгаарлахгүй.

5 дугаар зүйл

1. 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэгчийг оролцогч улсуудын хооронд байгуулсан хэрэгтэн шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээнд шилжүүлж өгөх хэрэгтэнд оруулан тооцох бөгөөд тэдгээрийн хооронд цаашид байгуулах хэрэгтэн шилжүүлэх тухай аливаа гэрээнд тухайн гэрээнд заасан нөхцлийн дагуу шилжүүлж өгөх хэрэгтэнд хамааруулан авч үзнэ.

2. Хэрэв оролцогч улс нь хэрэгтэн шилжүүлж өгөх гэрээний үндсэн дээр хэрэгтэн шилжүүлж өгөх гэрээ байгуулаагүй оролцогч өөр улсаас хэрэгтэнг шилжүүлэх талаар хүсэлт гаргавал тухайн улс энэхүү Протоколыг хэрэгтэн шилжүүлэх эрх зүйн үндэс хэмээн үзэж болно. Хэрэгтэнг хүсэлт хүлээж авсан тухайн улсын хуульд заасан нөхцлийн дагуу шилжүүлнэ.

3. Хэрэгтэнг шилжүүлж өгөх гэрээ байгуулаагүй оролцогч улсууд өөр хоорондоо тухайн гэмт хэрэг үйлдэгчийн хувьд хүсэлт хүлээж авсан улсын хуульд заасан нөхцлийн дагуу шилжүүлж өгөх хэрэгтэн хэмээн үзнэ.

4. Оролцогч улсуудын хооронд хэрэгтэн шилжүүлэх асуудлын тухайд гэмт хэргийг зөвхөн уг хэрэг гарсан газрын хэмжээнд бус 4 дүгээр зүйлийн дагуу өөрсдийн хууль эрх мэдлийн хүрээг тогтоовол зохих улсын нутаг дэвсгэр дээр гарснаар авч үзнэ.

5. Хэрэв хэрэгтэнг 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэргийн аль нэгтэй холбогдуулан шилжүүлж авах тухай хүсэлт гаргасан бөгөөд хүсэлт хүлээж авсан оролцогч улс хэрэгтнийг харьяаллын үндсэн дээр шилжүүлж өгөөгүй буюу өгөхгүй бол түүнийг эрүүгийн хэрэгт шалгуулахаар гэмт хэргийг өөрийн эрх бүхий байгууллагад шилжүүлэх талаар зохих арга хэмжээ авна.

6 дугаар зүйл

1. Оролцогч улсууд 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн тухайд хэрэгтэнг



илрүүлэх буюу эрүүгийн хэрэгт шалгах буюу түүнийг шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой асуудлаар харилцан бие биедээ бүхий л бололцоогоор туслах бөгөөд дурдсан байцаан шийтгэх ажиллагааг явуулахад шаардлагатай нотлох баримтыг олоход мөн тусална.

2. Оролцогч улсууд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ биелүүлэхдээ өөр хоорондоо байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх аливаа гэрээ буюу бусад тохиролцоог удирдлага болгоно. Ийм гэрээ буюу тохиролцоо байхгүй бол оролцогч улсууд дотоодын хууль тогтоомжийн дагуу өөр хоорондоо туслалцаа үзүүлнэ.

7 дугаар зүйл

Оролцогч улсууд үндэсний хууль тогтоомжид заасны дагуу:

(а) шаардлагатай үед дор дурдсан зүйлийг хураах болон дайчлах арга хэмжээ авна:

(i) энэхүү Протоколд заасан гэмт хэргийг үйлдэхэд ашиглаж байсан буюу гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэж байсан эд хөрөнгө, материал, хэрэгсэл болон багаж зэвсэг;

(ii) тухайн гэмт хэрэг үйлдэж олсон орлого;

(b) (а) дэд хэсгийн (i)-д заасан эд хөрөнгө болон орлогыг хураах буюу дайчлах тухай оролцогч нөгөө улсын хүсэлтийг биелүүлнэ;

(c) тухайн гэмт хэргийг үйлдэхэд ашиглаж байсан байрыг түр буюу тодорхой хугацаагаар хаахад чиглэсэн арга хэмжээ авна.

8 дугаар зүйл

1. Оролцогч улсууд энэхүү Протоколоор хориглосон гэмт хэрэгт өртөж, хохирогч болсон хүүхдийн эрх, ашиг сонирхлыг эрүүгийн шүүн таслах бүх ажиллагааны үед дор дурдсан арга замаар хамгаалах талаар зохих арга хэмжээ авна:

(а) гэмт хэрэгт өртөж хохирогч болсон хүүхдийн эмзэг байдлыг хүлээн зөвшөөрч, тэдний онцгой шаардлага, ялангуяа гэрч болохынх нь хувьд тэдгээрийн онцгой шаардлагыг хүлээн зөвшөөрсөн журам батлах;

(b) хохирогч болсон хүүхдэд тэдний эрх,





үүрэг болон шүүн таслах ажиллагааны агуулга, хугацаа болон явц, уг хэргийн талаархи шийдвэрийн тухай мэдээлэх;

(с) шүүн таслах ажиллагааны явцад үндэсний хууль тогтоомжийн байцаан шийтгэх хэм хэмжээний дагуу хохирогч хүүхдийн санаа бодол, шаардлага болон асуудлыг тэдгээрийн хувийн ашиг сонирхол хөндөгдсөн үед танилцуулж, хэлэлцүүлэх боломж олгох;

(d) шүүн таслах ажиллагааны явцад хохирогч хүүхдэд зохих дэмжлэг болох үйлчилгээ үзүүлэх;

(e) шаардлагатай үед хохирогч хүүхдийн амь нас, нэр төрийг хамгаалах болон үндэсний хууль тогтоомжийн дагуу хохирогч хүүхдийн нэрийг мэдэгдүүлсэн мэдээллийг зүй бусаар тараах явдлаас зайлсхийх арга хэмжээ авах;

(f) хохирогч хүүхэд, түүнчлэн түүний гэр бүлийнхний болон тэдний өмнөөс гэрчлэгчдийг аливаа сүрдүүлэг, өшөө хонзонгоос зохих үед хамгаалах арга хэмжээ авах;

(g) хохирогч хүүхдэд нөхөн төлбөр олгох тухай шүүхийн тогтоол болон шийдвэр гүйцэтгэлийг онцын шаардлагагүйгээр хойшлуулахаас зайлсхийнэ.

2. Оролцогч улсууд хохирогчийн насны талаар эргэлзээ гарвал үүнээс болж эрүүгийн мөрдөн байцаалт, тухайлбал, хохирогчийн насыг тогтоох зорилгоор мөрдөн байцаалт эхлүүлэхэд саад үүсэхгүй байх нөхцлийг хангана.

3. Оролцогч улсууд эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоонд энэхүү Протоколд дурдсан гэмт хэргийн хохирогч хүүхэдтэй харьцахдаа нэн түрүүн хүүхдийн хамгийн эрхэм дээд ашиг сонирхлыг баримтална.

4. Оролцогч улсууд энэхүү Протоколоор хориглосон гэмт хэргийн хохирогч хүүхэдтэй ажиллаж буй этгээдэд зохих сургалт, ялангуяа хууль эрх зүйн болон сэтгэл зүйн сургалтад хамруулах талаар арга хэмжээ авна.

5. Оролцогч улсууд тийм гэмт хэргээс урьдчилан сэргийлэх буюу хамгаалах болон





хохилогчдыг нөхөн сэргээхтэй холбогдсон үйл ажиллагаанд оролцож байгаа хүмүүс буюу байгууллагуудын аюулгүй байдал, халдашгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авна.

6. Энэ зүйлийн аливаа заалтыг шударга болон нөлөөнд үл автах шүүн таслах ажиллагаанд шүүгдэгчийн эрхэд хохирол учруулах буюу түүнийг зөрчих байдлаар тайлбарлахгүй.

9 дүгээр зүйл

1. Оролцогч улсууд энэхүү Протоколд заасан гэмт хэргээс сэргийлэх зорилгоор хууль, захиргааны арга хэмжээ, нийгмийн бодлого болон хөтөлбөрийг батлах буюу бэхжүүлэх, хэрэгжүүлэх болон сурталчилна. Ийм үйл ажиллагаанд ялангуяа эмзэг хүүхдийг хамгаалах талаар онцгой анхаарна.

2. Оролцогч улсууд зохих бүхий л хэрэгслийг ашиглан мэдээлэл тараах, боловсрол олгох, сургалт зохион байгуулах замаар энэхүү Протоколд заасан гэмт хэргийн хортой үр дагавар, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай олон нийт, түүний дотор хүүхдэд өргөнөөр таниулах ажилд тус дөхөм үзүүлнэ. Оролцогч улсууд энэ зүйлд заасны дагуу үүргээ биелүүлэхдээ хамт олон, ялангуяа хүүхэд болон хохирогч хүүхдийг мэдээлэл, сурталчилгаа сургалтын хөтөлбөр, ялангуяа олон улсын хэмжээнд оролцуулах талаар тэднийг хөхиүлэн дэмжинэ.

3. Оролцогч улсууд хохирогч хүүхдэд зохих дэмжлэг үзүүлж тэднийг нийгэмших, бие бялдрын болон сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх талаар бололцоотой бүх арга хэмжээ авна.

4. Оролцогч улсууд энэхүү Протоколд заасан гэмт хэргийн хохирогч бүх хүүхдийг хуулийн дагуу хариуцлага хүлээгчээс учирсан хохирлоо нөхүүлэх зохистой арга хэмжээнд аливаа байдлаар алагчилахгүйгээр хамруулах явдлыг хангана.

5. Оролцогч улсууд энэхүү Протоколд заасан гэмт хэргийг сурталчилж буй материалыг үйлдвэрлэх, тараах явдлыг үр дүнтэй



хориглоход чиглэсэн бүхий л зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл

1. Оролцогч улсууд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах, бэлгийн дур хүслээ хүүхдээр хангах аялал зэрэг үйл ажиллагаанд оролцсон этгээдийг таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн байцаах, эрүүгийн хэрэгт шалгах болон шийтгэх зорилгоор олон талт, бүс нутгийн болон хоёр талт тохиролцоо байгуулах замаар олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авна. Түүнчлэн оролцогч улсууд олон улсын хамтын ажиллагаа, өөрийн орны байгууллага, үндэсний болон олон улсын төрийн бус байгууллагууд, түүнчлэн олон улсын байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад дэмжлэг үзүүлнэ.

2. Оролцогч улсууд хохирогч хүүхдийг бие махбодь, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, эх орондоо буцахад нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3. Оролцогч улсууд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах, хүүхэд ашиглах секс аялалд нөлөөлж буй ядуурал болон хөгжлийн дорой байдал зэрэг шалтгааныг арилгах зорилгоор олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4. Оролцогч улсууд эл зорилгоор олон талт, бүс нутгийн, хоёр талт болон бусад хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн, техникийн болон бусад туслалцааг зохих боломжийн хэрээр үзүүлнэ.

11 дүгээр зүйл

Энэхүү Протоколын аливаа заалт хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд илүү дэмжлэг үзүүлэх талаар дор дурдсан заалтыг хөндөхгүй:

(a) үндэсний хууль тогтоомжид тусгагдсан;

(b) тухайн улсад үйлчилж буй олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан.

12 дугаар зүйл



1. Оролцогч улс бүр тухайн улсын хувьд энэхүү Протокол хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш хоёр жилийн дотор энэхүү Протоколын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор авсан арга хэмжээний талаархи дэлгэрэнгүй мэдээллийг тусгасан тайланг Хүүхдийн эрхийн хороонд хүргүүлнэ.

2. Дэлгэрэнгүй тайлан өгсний дараа оролцогч улс бүр Конвенцийн 44 дүгээр зүйлд заасны дагуу Протоколын хэрэгжилттэй холбоотой аливаа нэмэлт мэдээллийг Хүүхдийн эрхийн хороонд хүргүүлсэн тайландаа тусгана. Протоколын оролцогч бусад улс тайланг таван жил тутам гаргана.

3. Хүүхдийн эрхийн хороо энэхүү Протоколын хэрэгжилттэй холбоотой холбогдох нэмэлт мэдээллийг оролцогч улсаас хүсч болно.

13 дугаар зүйл

1. Энэхүү Протокол нь Конвенцийн оролцогч буюу түүнд гарын үсэг зурсан аливаа улсын хувьд гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Энэхүү Протоколыг соёрхон батлах бөгөөд Конвенцийн оролцогч буюу түүнд гарын үсэг зурсан аливаа улсын хувьд нэгдэн ороход нээлттэй байна. Соёрхон батласан буюу нэгдэн орсон батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

14 дүгээр зүйл

1. Энэхүү Протокол нь соёрхон батласан буюу нэгдэн орсон арав дахь батламж жуух бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Протоколыг соёрхон баталж байгаа буюу түүнд нэгдэн орж байгаа улс бүрийн хувьд энэхүү Протокол нь батламж жуух бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш нэг сарын дараа хүчин төгөлдөр болно.

15 дугаар зүйл

1. Оролцогч аливаа улс энэхүү Протоколыг аливаа үед Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэж цуцалж болох бөгөөд тэрбээр Конвенцид оролцогч бусад улс буюу



Конвенцид гарын үсэг зурсан улсад энэ тухай мэдээлнэ. Цуцлалт нь Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүлээж авсан өдрөөс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Цуцлалт нь энэхүү Протоколд дурдсан үүргээс оролцогч улсыг цуцлалт хүчин төгөлдөр болохоос өмнөх аливаа гэмт хэргийн хувьд чөлөөлөхгүй. Түүнчлэн цуцлалт нь хүчин төгөлдөр болохоос өмнө хороогоор нэгэнт хэлэлцэж эхэлсэн аливаа асуудлыг цаашид үргэлжлүүлэн хэлэлцэхэд ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй.

16 дугаар зүйл

1. Оролцогч аливаа улс Протоколд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болох бөгөөд түүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга санал болгож байгаа нэмэлт өөрчлөлтийн тухай оролцогч улсуудад мэдээлэхийн хамт, уг саналыг хэлэлцэх бага хурал хийлгэх эсэх талаар саналаа ирүүлэхийг тэднээс хүснэ. Ийнхүү мэдээлсэн өдрөөс хойш дөрвөн сарын дотор оролцогч улсуудын гуравны нэгээс доошгүй нь бага хурал хуралдуулахыг зөвшөөрвөл Ерөнхий нарийн бичгийн дарга Нэгдсэн Үндэстний Байгууллагын ивээлийн дор уг бага хурлыг хуралдуулна. Бага хуралд хүрэлцэн ирж оролцсон оролцогч улсуудын олонхийн саналаар дэмжигдсэн аливаа нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар Ерөнхий Ассамблейд өргөн мэдүүлнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нэмэлт өөрчлөлт нь түүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн чуулганаар батласнаар болон оролцогч улсуудын гуравны хоёр нь хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно.

3. Нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа түүнийг хүлээн зөвшөөрсөн оролцогч улсууд дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд оролцогч бусад улсын хувьд энэхүү Протоколын заалтууд болон тэдгээрээс өмнө нь батласан нэмэлт өөрчлөлтийг дагаж

мөрдөнө.

17 дугаар зүйл

1. Энэхүү Протоколын араб, хятад, англи, франц, орос болон испани хэлээрх эх бичвэрүүд адил хүчинтэй бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын архивд хадгалагдана.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Протоколын баталгаат хувийг Конвенийн оролцогч бүх улс болон Конвенцид гарын үсэг зурсан бүх улсад илгээнэ.